



ДААТГАЛ
SINCE 1994

2019

Ард Даатгал

ЖИЛИЙН ТАЙЛАН

Ирээдүйг
таахгүй ч
эрсдэлийг
удирдана



An aerial photograph of Ulaanbaatar, Mongolia, showing a dense urban landscape with various high-rise buildings. The most prominent feature is 'The Blue Sky' building, a tall, curved skyscraper with a glass facade. Other buildings of varying heights and architectural styles are visible in the background, set against a backdrop of rolling hills under a cloudy sky.

МОНГОЛЫН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол улсад даатгалын салбар үүсч хөгжөөд 86 жил болж байгаа ба анхны хувийн даатгалын компани болох Ард Даатгал компани нь 1994 онд байгуулагдсан.

2019 онд даатгалын зах зээлд ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, дотоодын давхар даатгалын 2, даатгалын зуучлалын 54, даатгалын хохирол үнэлэгч 27 компани тус тус үйл ажиллагаа явуулсан байна.

Даатгалын салбарын голлох үзүүлэлт

Нийт хөрөнгө


Тайлант хугацаанд даатгалын компаниудын нийт хөрөнгө 365.85 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 33.9 тэрбум төгрөгөөр буюу 10 хувиар өссөн байна. Энэхүү өсөлт нь зарим даатгалын компанийн үйл ажиллагаа өргөжиж, хуримтлагдсан ашиг, хураамжийн орлого түүнийг дагаад даатгалын нөөц сан нэмэгдсэнтэй холбоотой юм. Үүнээс ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 281 тэрбум төгрөг байгаа нийт даатгалын салбарын 77 хувийг эзэлж, өмнөх онтой харьцуулахад 11 хувийн өсөлттэй байна.

Хураамж, нөхөн төлбөр

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 2019 онд нийт 196.6 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн орлоготой ажилласнаас 99.4 хувь буюу 195.3 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.6 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани тус тус бүрдүүлсэн. Ердийн даатгалын компаниуд нийт хураамжаас 7.2 тэрбум төгрөгийн хураамжийн буцаалт хийгдэж, 57.3 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамжийн зардалд зарцуулснаар даатгалын цэвэр хураамжийн орлого 130.9 тэрбум төгрөгт хүрсэн байна. Даатгалын нийт хураамжийн орлого ДНБ –ний 0.53 хувьтай тэнцүү байна.

Ердийн даатгалын үзүүлэлтүүд


Нийт хөрөнгө /тэрбум төгрөг/




Нийт хураамжийн орлого /тэрбум төгрөг/



Нийт нөөц сан /тэрбум төгрөг/



Цэвэр хураамжийн орлого /тэрбум төгрөг/




Давхар даатгал


Тайлант хугацаанд ердийн даатгалын компаниуд нийт 65.0 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг даатгуулагчид олгосноос 11.8 тэрбум төгрөгийг давхар даатгагч, 1.7 тэрбум төгрөгийг буруутай этгээд, 51.5 тэрбум төгрөгийг даатгагч нар тус тус төлсөн байна.

2018 онтой харьцуулбал даатгалын компаниудын олгосон нөхөн төлбөр 14 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Нийт нөхөн төлбөр /тэрбум төгрөг/




Цэвэр нөхөн төлбөр /тэрбум төгрөг/



Ердийн даатгалын компаниуд 2019 онд 91.2 их наяд төгрөгийн даатгалын үнэлгээ бүхий эрсдэлийг хүлээн авсан байна. Компаниуд хүлээсэн эрсдэлээ давхар даатгуулах хандлага жил ирэх тусам нэмэгдэж байгаа ба 2019 оны байдлаар 57.3 тэрбум ердийн даатгалын компаниуд нийт 57.3 тэрбум төгрөгийн давхар даатгалын хураамжийн зардал гаргасан бөгөөд үүний 3.7 хувь буюу 2.1 тэрбум төгрөгийг дотоод давхар даатгагчдад даатгуулахад зарцуулсан байна

Давхар даатгалын зардал /тэрбум төгрөг/



Даатгалын бүтээгдэхүүн

Манай улсад даатгалын үйл ажиллагааг Санхүүгийн Зохицуулах Хорооноос зохицуулж, борлуулах даатгалын хэлбэрийн стандартыг баталдаг ба тухайн хэлбэрт тохирох даатгалын бүтээгдэхүүнийг компани өөрөө загварчилдаг. Компани бүтээгдэхүүнийг борлуулахаас өмнө СЗХ-оор хянуулан батлуулдаг.

СЗХ-оос ердийн даатгалын 17 хэлбэрийг баталсан бөгөөд үүнээс 5 даатгалын хэлбэр жил бүрийн хураамжийн орлогод голлох оролцоотой байдаг. 2019 оны байдлаар голлох 5 бүтээгдэхүүн нийт хураамжийн 82 хувийг бүрдүүлсэн байна. Үүнд:

21%

Хөрөнгийн даатгал

19%

Жолоочийн хариуцлагын даатгал

18%

Авто тээврийн хэрэгслийн даатгал

17%

Гэнэтийн осол, эмчилгээний даатгал

7%

Хариуцлагын даатгал

18%

Бусад

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ТУЗ-ийн ээлжит хурал 2019 оны 2 сарын 18-ны өдөр хуралдаж 2018 оны цэвэр ашгийн 50 хувь буюу 631 сая төгрөгийн ногдол ашиг тараахаар шийдвэрлэв. Ногдол ашгийг анх удаа компанийн байранд 6 сарын 17-ны өдрөөс 26-ны өдрийн хооронд тараасан бөгөөд тухайн хугацаанд ногдол ашгаа авч амжаагүй хувьцаа эзэмшигчдэд ҮЦТХТ-өөр дамжуулан 6 сарын 28-ны өдөр олгов.



Ард Даатгал ХК-ийн үүсгэн байгуулагч Ц.Тогтохбаяр нь Ардын хувьсгалын 98 жилийн ойн баяраар Монгол Улсын Гавьяат Эдийн засагч цолоор, мөн ахмад ажилтан Б.Янжмаа нь Төрийн дээд шагнал Алтан гадас одонгоор тус тус шагнагдлаа.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 4 сарын 27-ны өдөр хуралдаж 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг баталж, ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ч.Ганхуяг, О.Одбаяр, Г.Цогбадрах, Ч.Ганзориг, Б.Золбоо, С.Оргил ТУЗ-ийн хараат бус гишүүнээр З.Ариун, Б.Болорчимэг нар улиран сонгогдож, И.Сэр-Одыг шинээр томилох шийдвэрийг тус тус гаргалаа.

“Ард Койн” урамшуулалт хөтөлбөрийн хүрээнд сүүлийн 3 жил осол гаргаагүй осолгүй, манлай жолооч, даатгуулагчиддаа 1,000-3,000 ширхэг Ард Койн олголоо. Мөн сайн дурын даатгал хийлгэсэн даатгуулагчид Ард Койны урамшуулалтай борлуулалтын аян хийж иргэдийн даатгалын оролцоог нэмэгдүүлэхээр дэмжиж ажиллаж байна.

Шинээр сонгогдсон ТУЗ нь Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо болон Эрсдэл хөрөнгө оруулалтын хороог шинэчлэн байгуулж, бүтэц бүрэлдэхүүнийг тогтов.

Эрүүл мэндийн даатгалыг хүртээмжтэй болгох, бүтээгдэхүүний өртгийг бууруулах, төлбөрийг түргэн шуурхай шийдэх боломжуудыг нээсэн гар утасны Insur апп шийдлийг боловсруулсан Insur компанитай хамтарч ажиллах санамж бичиг байгуулж, борлуулалтыг эхэллээ.



Ард Лайф ХХК-тай хамтран Дэлхийн жишигт хүрсэн тэтгэврийн сангийн тогтолцоог нутагшуулах зорилгоор "Гурвалсан тэтгэврийн хуримтлал"-ын бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.

Монгол дахь Австралийн Худалдааны Танхимын гишүүнээр элсэж, тус танхимаас зохион байгуулдаг арга хэмжээг ивээн тэтгэж, тогтмол хамтран ажиллаж байна.

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП 20 индексэд хоёр жил дараалан багтаж чадлаа.

Төлөвлөгөө гүйцэтгэлээр шалгарсан орон нутгийн зарим салбарууд болон нөхөн төлбөрийн шуурхай албанд шинээр автомашин худалдан авлаа.





ДААТГАЛЫН

er. Together.




ҮЙЛ АЖИЛЛАГАА


Ард Даатгал ХК нь 2019 онд Улаанбаатар хот болон орон нутагт нийт 21 салбар, 96 төлөөлөгч, зуучдаар дамжуулан нийт 116,000 орчим даатгуулагчидтай хамтран ажиллаж, нийт 11.4 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийг төвлөрүүлсэн амжилттай ажиллалаа. Бидэнтэй хамт байсан, үйлчлүүлсэн 117 мянган харилцагч, даатгуулагчиддаа баярлалаа.

	Хувь хүн	Хуулийн этгээд	Нийт
2018 он	113,598	1,940	115,538
2019 он	114,040	2,406	116,446


Даатгуулагчийн тоо



Хураамжийн орлого /тэрбум төгрөг/



Нийт хураамжийн орлогод даатгалын бүтээгдэхүүнүүдийн эзлэх хувийг харуулбал:



Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимаас жил бүр шалгаруулдаг шилдэг 100 компаниас 70 гаруй компанитай бид даатгалын үйлчилгээгээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, Монгол орны хөгжил дэвшилд тодорхой хувь нэмэр оруулан үйл ажиллагаагаа явуулдаг уул уурхай, барилга, зам тээвэр, эрчим хүчний гэх мэт бүхий л салбаруудын төлөөлөл болсон томоохон компаниудтай урт удаан

хугацаанд, үр дүнтэйгээр хамтран ажиллаж байна. 2019 онд Ард Даатгал ХК нь төрийн өмчийн болон хувийн хэвшлийн байгууллагуудаас зарласан 42 тендер шалгаруулалтад оролцож, үүнээс 8 тендерт шалгарч гэрээ байгууллаа. Зах зээл дээрх ширүүн өрсөлдөөн, өндөр эрсдэл, хохирлын харьцаа, үнийн хэт туйлшрал, хамгийн бага үнэ өгсөн оролцогчийг сонгох хуулийн зохицуулалт зэрэг нь бидний зүгээс

тендерт ялагдах гол шалтгаан болсон байна. Нөгөө талаас бүтээгдэхүүний нөхцөлийг улам сайжруулж, эрсдэлийн санг хангалттай байгуулж, компанийн эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, зарим даатгалын хэлбэрээр давхар даатгалын хамгаалалт авч дараа дараагийн уралдаант шалгаруулалтад оролцоход анхаарч ажиллах шаардлагатай байна.

Иргэдийн даатгал / Байгууллагын даатгалын харьцаа:



51%
Байгууллагын
даатгал



49%
Иргэдийн
даатгал

Орон нутаг дахь даатгалын үйл ажиллагаа

2019 онд салбаруудын борлуулалт өмнөх оноос 29 хувиар нэмэгдсэн нь Ард Даатгал ХК-д итгэх даатгуулагчдын тоо орон нутагт жил бүр тогтмол өссөөр байгааг харуулж байна. Өнөөдрийн байдлаар Ард Даатгал ХК нь хөдөө орон нутагт 2-3 хүний орон тоотой нийт 21 салбар нэгжийг ажиллуулж байна. Салбарууд нь даатгалын борлуулалт хийхийн зэрэгцээ аймаг орон нутагт гарсан даатгалын тохиолдлын дуудлагад хариулан, нөхөн төлбөрийн материал хүлээн авч, харилцагчдад шаардлагатай мэдээлэл түгээн, тэргүүн шугамд ажиллаж байна. Хавар 3 сараас сумын төв болон томоохон суурин тосгодоор тойрон явж, жолоочийн хариуцлага болон тээврийн хэрэгслийн даатгалыг улсын хэмжээний оношилгооны үеэр идэвхтэй хийхийн зэрэгцээ малчдад зориулсан Малын Индексжүүлсэн Даатгалын борлуулалтыг нэлээдгүй хийж байна.

2020 онд орон нутгийн салбаруудын борлуулалтыг 45.5 хувиар нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж, нийт хураамжийн орлогод эзлэх салбарын борлуулалтыг 16 хувьд хүргэхээр ажиллаж байна.


2019 оны 12 сард хөдөө орон нутгийн 5 салбарт шинэ автомашин хүлээлгэн өгсөн бөгөөд цаашид ч бусад салбаруудыг автомашинаар хангах бодлого барьж ажиллаж байна. Борлуулалтын төлөвлөгөөг биелүүлэхэд энэхүү арга хэмжээ нь түлхэц болох нь гарцаагүй бөгөөд салбарын ажиллагсдыг давтан сургалтад хамруулах, бүтээгдэхүүнийг сайжруулж маркетингийн хувьд дэмжлэг үзүүлж ажиллан, хөдөө орон нутгийн зах зээлийн өрсөлдөөнт орчинд ялагч болох боломжтой юм.



Малын Индексжүүлсэн даатгал /МИД/

АрдДаатгалХК нь 2016 оноос эхлэн малчдад Малын Индексжүүлсэн Даатгалыг санал болгон ажиллаж эхэлсэн бөгөөд 2019 онд 2,500 орчим малчинтай МИД-ын гэрээ байгуулж 341.3 сая төгрөгийн даатгалын хураамж төвлөрүүлэн ажилласан нь өмнөх онтой харьцуулахад 14.7 хувийн өсөлтийг үзүүлэн ажилласан байна. Өнөөдрийн байдлаар МИД-ыг хөдөө орон нутагт салбартай даатгалын компаниуд санал болгож байгаа бөгөөд арилжааны банкууд энэ даатгалын борлуулалтыг түлхүү хийх болсон. Арилжааны банкаар хийгдэж байгаа МИД-ын борлуулалт 2018 онтой харьцуулбал 25.01 хувь өссөн бөгөөд энэхүү бүтээгдэхүүн нь Монголиан Ре хэмээх үндэсний давхар даатгалын компанид давхар даатгагддаг онцлогтой юм.

Зах зээлд эзлэх хувь



Газар тариалангийн даатгал

Ард Даатгал ХК нь газар тариалангийн даатгалын анхдагч компаниудын нэг бөгөөд 2019 онд 4 аймгийн 5 аж ахуйн нэгжийн 782.1 га талбайг даатган ажилласан байна.

Газар тариалангийн даатгалаар 2019 онд нөхөн төлбөр бүртгэгдээгүй бөгөөд даатгагдсан аж ахуйн нэгжүүдийн хувьд ургац алдсан, цаг агаарын холбогдолтойгоор хохирол учирсан зүйл гараагүй байна.

Эрүүл мэнд, Гэнэтийн ослын даатгал

Энэ онд манай эрүүл мэндийн даатгалын баг хамт олон 64,400 даатгуулагчид 1.6 их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг үзүүлсэн ба үүнээс 1200 орчим даатгуулагчид хагас тэрбум гаруй төгрөгийн нөхөн төлбөрийг олгосон байна.



НӨХӨН ТӨЛБӨР

Ард Даатгал ХК нь 2019 онд 5,152 даатгуулагчийн 4.4 тэрбум төгрөгийн хохирлыг нөхөн төлж, даатгалын гэрээний үүргээ бүрэн биелүүллээ. Тайлант хугацаанд манай компани давхар даатгалын компаниудтай амжилттай хамтран ажиллаж нийт хохирлын 10 хувь буюу 451 сая төгрөгийг давхар даатгагчаар төлүүлж үлдсэн хэсгийг өөрийн нөөц сангаас төлсөн.

Нийт нөхөн төлбөр /сая.төг/

Даатгалын хэлбэр	2018 он	Эзлэх хувь	2019 он	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	341.4	5.7%	543.9	12.3%
Хөрөнгийн даатгал	231.9	3.9%	435.4	9.8%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,435.4	23.9%	1,304.1	29.5%
Барилга угсралтын даатгал	2,271.1	37.8%	3.3	0.1%
Зээлийн даатгал	318.7	5.3%	664.8	15.0%
Жолоочийн хариуцлагын даатгал	1,072.9	17.8%	1,286.3	29.1%
Бусад	341.0	5.7%	185.7	4.2%
Нийт дүн	6,012.37	100%	4,423.4	100%

Олгосон нөхөн төлбөрийн дүн 2018 оны үетэй байна. Бусад даатгалуудын тухайд нөхөн төлбөрийн харьцуулахад 26 хувиар буурсан нь барилга хэмжээ нь өссөн үзүүлэлттэй байна. угсралтын даатгалын нөхөн төлбөрөөс шалтгаалсан

Бүтээгдэхүүний төрлөөр давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрийг харуулбал:

Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	43%
Хөрөнгийн даатгал	57%

Цэвэр нөхөн төлбөр /сая.төг/

Даатгагч өөрийн нөөц сангаас төлсөн нөхөн төлбөрийг өмнөх онтой харьцуулан даатгалын хэлбэрээр задлан харуулбал:

Даатгалын хэлбэр	2018 он	Эзлэх хувь	2019 он	Эзлэх хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	318.7	9.1%	349.2	8.8%
Хөрөнгийн даатгал	231.9	6.6%	179.4	4.5%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,434.2	41.1%	1,301.3	32.9%
Барилга угсралтын даатгал	61.4	1.8%	3.3	0.1%
Зээлийн даатгал	198.1	5.7%	664.8	16.8%
Жолоочийн хариуцлагын даатгал	1,068.3	30.6%	1,277.2	32.2%
Бусад	175.3	5.0%	185.7	4.7%
Нийт дүн	3,487.87		3,960.7	

Олгосон нөхөн төлбөрийн дүнгийн өсөлтөд зарим даатгалын хэлбэрүүдийн борлуулалт өссөн бөгөөд Зээлийн даатгалын нөхөн төлбөр огцом өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

Нөхөн төлбөрийн тоо

Даатгалын хэлбэр	2018 он	2019 он
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	876	1,151
Хөрөнгийн даатгал	54	121
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,271	1,427
Барилга угсралтын даатгал	7	1
Зээлийн даатгал	142	112
Жолоочийн хариуцлагын даатгал	1,780	2,140
Бусад	199	200
Нийт дүн	4,329	5,152

2019 онд бид иргэдийн даатгалд хүртээмжтэй ажиллаж даатгуулагчдын тоо өссөн бөгөөд энэ нь нөхөн төлбөрийн тоо өсөхөд голлон нөлөөлсөн байна.

Нэгж нөхөн төлбөр /сая төгрөг/


Даатгалын хэлбэр	2018 он	2019 он
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	0.39	0.47
Хөрөнгийн даатгал	4.29	3.60
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1.13	0.91
Барилга угсралтын даатгал	324.44	3.27
Зээлийн даатгал	2.24	5.94
Жолоочийн хариуцлагын даатгал	0.60	0.60
Бусад	1.71	0.93
Дундаж дүн	1.39	0.86

2019 оны хувьд нэгж хохирлын хэмжээ 0.86 сая төгрөг болж дунджаар өмнөх оноос 530 мянган төгрөгөөр буурсан байна.

Татгалзсан нөхөн төлбөр

Бид даатгуулагчдын өмнө хүлээсэн гэрээний үүргээ биелүүлж хохирол тохиолдсон даатгуулагчдад нөхөн төлбөр төлөхийн зэрэгцээ мөн нийт бусад

даатгуулагчдын дундын нөөц санг хамгаалж, санг зохистой удирдах үүрэгтэй ажилладаг. 2019 онд нийт 339 даатгалын тохиолдолд 721 сая төгрөгийн нэхэмжлэлд татгалзсан шийдвэр гаргаж ажилласан бөгөөд гэрээнд хамрагдахгүй нөхцөлтэй, хохирлыг нотлох боломжгүй, мөн даатгагчийг хууран мэхлэх үйлдлүүд нь нөхөн төлбөр татгалзах голлох шалтгаан болсон байна.

A grayscale photograph of a hand placing a wooden block on a bar chart. The hand is positioned over the chart, with the index finger pointing towards the blocks. The chart consists of several wooden blocks of varying heights, representing a bar graph. The background is a plain, light-colored surface.

ЭРСДЭЛИЙН ШИНЖИЛГЭЭ


Эрсдэл хүлээн авч түүнээс боломж бий болгох нь бизнес эрхлэгчдийн амжилтад хүрэх хүчин зүйлсийн салшгүй нэг хэсэг билээ. Даатгалын бизнесийн хувьд бид харилцагчдын даатгаж болохуйц эрсдэлүүдийг нэгтгэн хүлээн авч их тооны хуульд үндэслэн эрсдэлээ удирдаж, боломжийг бий болгодог.

Тайлант онд бид эрсдэлийн удирдлагын чиглэлээр тодорхой алхамуудыг амжилттай хийсний үр дүнд дараах үзүүлэлтүүдэд ахиц дэвшил гарсан байна

1. Андеррайтинг

Ердийн даатгалд андеррайтинг нь даатгах эрсдэлийг тооцож, хянах үйл ажиллагааг хэлнэ. Үүнд даатгалын хураамжийн зохистой байдал, даатгалд хамруулах нөхцөл, даатгалын багц дахь эрсдэл зэргийг үнэлэх үйл ажиллагаа хамаарна.

Даатгалын андеррайтингийн үйл ажиллагааг үнэлэх гол үзүүлэлтүүд нь хохирлын болон зардлын харьцаанууд юм.



2019 онд хосолсон харьцаа өссөн ба энэ нь цэвэр хураамж 7.4% бууралт болон цэвэр нөхөн төлбөр 13.6%, үйл ажиллагааны зардал 21% -р тус тус өссөнтэй хамааралтай.

2. Төлбөрийн чадвар

Даатгуулагчийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь бүрэн биелүүлэхэд хүрэлцэхүйц хэмжээний хөрөнгөтэй эсэх, төлбөрийн чадвар

нь зохих түвшинд хангагдсан эсэхийг төлбөрийн чадварын үзүүлэлт болон эздийн өмчийн хэмжээ мөн илэрхийлнэ.

	Зохистой харьцаа	2018 он	2019 он
Төлбөрийн чадварын зохистой харьцаа	=>110%	109.5%	123.1%

Төлбөрийн чадварын хувь нь 2018 оны үетэй харьцуулахад 13.5 хувиар өсөж 2019 сүүлийн байдлаар 123.1 хувьтай байна.

2019 оны хувьд хуримтлагдсан ашиг 44.5 хувь өссөнтэй холбоотой эздийн өмч 10 хувь өссөн байна.


	2018 он	2019 он
Эздийн өмч	10.7 тэрбум төгрөг	11.8 тэрбум төгрөг

3. Нөөц сан

Нөөц сан нь төлбөрийн чадварын үзүүлэлтийг илтгэдэг гол үзүүлэлтүүдийн нэг билээ.

Сүүлийн 3 жилийн нөөц сангийн өсөлт дараах байдалтай байна.

Нөөц сангийн дүн /тэрбум төгрөг/



2019 оны эцсийн байдлаар 3 тэрбум төгрөгийн нөөц сантай байна. Нөөц сангийн хэмжээ нь жил бүр 30 гаруй хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэхүү өсөлт нь манай компанийн даатгуулагчийн өмнө хүлээх хариуцлагын чадамж улам нэмэгдэж байгааг харуулсан баталгаа юм.

4. Давхар даатгал

Бид харилцагчдынхаа үйл ажиллагааны чиглэлээс хамаарч Давхар даатгалтай бүтээгдэхүүний багцаа төрөлжүүлэхэд чиглэсэн стратегийг хэрэгжүүлэн шинэ бизнесийн боломжуудыг нээн илрүүлж, давхар даатгагч нартай хийсэн стратегийн түншлэлийн туслалцаатайгаар шинэ зах зээлд нэвтрэх аргачлал туршлага хуримтлуулан амжилтаа бататган ажилласаар байна.

Ард Даатгал ХК нь 2019 онд 11.4 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажилласан ба үүний 2.1 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын компанид шилжүүлж эрсдэлээ тараан байршуулсан бөгөөд энэ нь өмнөх жилийн мөн үетэй харьцуулбал давхар даатгалын хураамжийн зардал 35 хувиар буурсан байна. Учир нь 2018 онд хувьцаат компани болсноор эздийн өмч хоёр дахин нэмэгдэж компанийн эрсдэл даах чадамж өсч өөрт үлдэх эрсдэлийн хэмжээг нэмэгдүүлж үүгээр давхар даатгалд шилжүүлэх эрсдэлийн хэмжээ буурсан байна.

Давхар даатгалын хэлбэр:

Даатгалын хэлбэр	2018	Хувь	2019	Хувь
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	259.2	8.19%	400.7	19.25%
Хөрөнгийн даатгал	749.8	23.70%	1,230.6	59.10%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	708.4	22.39%	0.0	0.00%
Ачааны даатгал	31.1	0.98%	33.5	1.61%
Барилга угсралтын даатгал	879.0	27.79%	100.8	4.84%
Газар тариалангийн даатгал	38.2	1.21%	18.2	0.87%
Мал амьтдын даатгал	108.3	3.43%	102.4	4.92%
Хариуцлагын даатгал	389.2	12.30%	184.3	8.85%
Санхүүгийн даатгал	0.2	0.01%	11.6	0.56%
Нийт	3,163.5	100%	2,082.1	100%

Эрүүл мэндийн даатгал болон хөрөнгийн даатгалаар нийт давхар даатгалын хураамжийн 78.35 хувь эзэлж байгаа бөгөөд, өмнө оны үзүүлэлтээс

61 хувийн өсөлттэй байна. Уг өсөлт нь олон улсын эрүүл мэндийн даатгалын борлуулалт өссөнтэй холбоотой юм.

Давхар даатгалын хэлбэр /сая төгрөг/

Давхар даатгалын төрөл	2018	Хувь	2019	Хувь
Факультатив	2,141.2	67.69%	1,102.3	52.94%
Фронтинг	997.1	31.52%	946.3	45.45%
Трити	25.2	0.80%	33.5	1.61%
Нийт	3,163.5	100%	2,082.1	100%


Компанийн өөрийн эрсдэл даах чадамж өссөнөөс гадна бид Трити гэрээгээр ХБНГУ-ын Hannover Re давхар даатгалын компанитай 4 дэх жилдээ хамтран ажиллаж (Whole Account Excess of Loss) Treaty гэрээгээр 2 сая долларын автомат хамгаалалт авч, 2 сая доллараас давсан гэрээ болгоныг тухай бүрт нь (Facultative) давхар даатгалд хамруулан ажилласан байна. Уг гэрээ нь манай эрсдэл даах чадамжийг нэмэгдүүлэхээс гадна харилцагчдад хамгийн найдвартай, өндөр түвшний даатгалын хамгаалалт юм.

Мөн Олон улсын эрүүл мэндийн даатгал болон Гадаад зорчигчдын даатгалыг бид Quota Share давхар даатгалд хамруулж дэлхийн бүх оронд үйлчлэх даатгалын цогц хамгаалалтыг харилцагчиддаа үзүүлж байна.



ХУВЬЦААНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

52 долоо хоног	₮599 - ₮800	Хаалтын үнэ	₮800
Нийт хувьцааны тоо	25,000,000	Дансны үнэ	₮472
Зах зээлийн үнэлгээ	₮19.99 тэрбум	P/E - Үнэ/Ашиг	11.66
Нийт арилжааны дүн	₮2.18 тэрбум	P/B - Үнэ/Дансны үнэ	1.69



Хувьцааны тоо	Нийтэд эзлэх %	ХЭ тоо
Байгууллага		
21,172,433	84.6%	13
Гадаадын иргэн		
139,464	0.6%	19
Дотоодын иргэн		
3,688,103	14.8%	1,605





КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн засаглал нь компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад сонирхогч талуудын хоорондох харилцааны багц асуудлууд болон компанийн зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэх бүтэц, арга зам, хэрэгжилтийг хянах хяналтын тогтолцоог тодорхойлно.

Засаглал

Ард Даатгал ХК нь Монголын Хөрөнгийн Биржийн хувьцааны бүртгэлийн 1-р ангилалд багтдаг нээлттэй, хувьцаат компани билээ. 2018 онд Ард Даатгалын хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны дараа нийт 1,359 хувьцаа эзэмшигчтэй болж байсан бол 2019 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар бид 1,637 хувьцаа эзэмшигчидтэй болсон байна.

Ард Даатгал ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд түүний чөлөөт цагт компанийн үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас томилогдсон 9 гишүүний бүрэлдэхүүнтэй Төлөөлөн Удирдах Зөвлөл удирдана.

Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хувь хүн буюу Гүйцэтгэх захирал хэрэгжүүлэх бөгөөд Гүйцэтгэх захирлыг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс томилно.

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, компанийг өөрчлөн байгуулах, ТУЗ-ийн гишүүнийг сонгох, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах, компанийн хэлбэрийг өөрчлөх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг байна.

Ард Даатгал ХК нь Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит хурлаа 2019 оны 4 сарын 27-ны өдөр Зайсан Хилл Цогцолборт зохион байгууллаа. Хуралд нийт 19,948,558 ширхэг саналын эрх бүхий хувьцаа эзэмшигчид оролцож, 79.79 хувийн ирцтэйгээр хуралдан дараах асуудлуудыг хэлэлцэн батлав.

1. Ард Даатгал ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг 99.99%-ийн саналаар батлав.
2. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийг сонгохдоо кумулятив аргаар санал хураалт явуулан, ТУЗ-ийн ердийн гишүүдээр Ч.Ганхуяг, О.Одбаяр Г.Цогбадрах, Б.Золбоо, Ч.Ганзориг, С.Оргил нарыг, хараат бус гишүүнээр Б.Болорчимэг, З.Ариун, И.Сэр-Од нарыг тус тус 2 жилийн хугацаатайгаар сонгов.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Ард Даатгал ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар шийдвэр гаргаж ажилладаг.

2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас ТУЗ-ийн гишүүдийг 2 жилийн хугацаатай сонгосон бөгөөд Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-д "Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба

тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна" гэж заасны дагуу өнөөдрийн байдлаар 6 ердийн, 3 хараат бус гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. ТУЗ-ийн даргаар Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн гүйцэтгэх захирал Чулууны Ганхуяг ажиллаж байна.

ТУЗ-өөс жил бүр компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, улирал тутам хуралдан төлөвлөгөөний биелэлтийг тайлангаар хянан, холбогдох үүрэг, чиглүүлгийг өгч ажиллаж байна.



Чулуун Ганхуяг

ТУЗ-ийн дарга

Чулууны Ганхуяг нь 1992 онд Нийслэлийн арван жилийн 23-р дунд сургууль, 1997 онд Унгар Улсын Будапешт хотын Корвинус Эдийн Засгийн Их Сургуулийг тус тус дүүргэсэн. Тэрээр Монгол Банкнд хянан шалгагч, НҮБ-ын бичил санхүүгийн Микростарт төсөл дээр Санхүүгийн менежер, Хөгжлийн Алтан Сан (Х.А.С) ББСБ, ХасБанк,

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл компаниудад Гүйцэтгэх захирлаар ажилласан туршлагатай. 2010-2012 оны хооронд Монгол Улсын Сангийн Яамны Дэд сайдын албан тушаалыг хашиж байв. Ч.Ганхуяг нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн үүсгэн байгуулагчдын нэг төдийгүй, өдгөө тус компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Одончимэд **Одбаяр**

ТУЗ-ийн ердийн гишүүн

О.Одбаяр нь 1984 онд Нийслэлийн 10 жилийн 13-р дунд сургууль, 1988 онд Украин Улсын Киев хотын Багшийн Их Сургууль, 1997 онд АНУ-ын Флоридагийн Техникийн Их Сургууль, 2000 онд "Отгонтэнгэр" Их Сургууль, 2018 онд АНУ-ын Бостон хотын Харвардын Их Сургуулийг тус тус дүүргэсэн.

Тэрээр Монгол Улсын Их Сургуульд багш, Монгол-Хятадын хамтарсан "Си Эм Эйч" төрийн өмчит компанийн Монголын талын Гүйцэтгэх захирал, "МИАТ" ХК-ийн Бээжин дэх төлөөлөгч, Монгол

Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-ны Атташе, Гуравдугаар нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх, "Чингис Хаан зочид буудал цогцолбор" ХХК-ийн Гүйцэтгэх захирал, "Алтай Холдинг" ХХК-ийн дэд ерөнхийлөгчөөр тус тус ажилласан туршлагатай. 2016 оноос "Эрдэнэс Монгол" ХХК-ийн Бизнес хөгжил эрхэлсэн дэд захирал, "Эрдэнэс Стийл" ХХК, "Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Гашуун Сухайт Автозам" ХХК, "Арева Монгол" ХХК, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Кредит ББСБ ХК, Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалыг тус тус хашиж байна.



Галбадрах **Цогбадрах**

ТУЗ-ийн ердийн гишүүн

Г.Цогбадрах нь 1992 онд Нийслэлийн 10 жилийн 33-р дунд сургууль, 1997 онд МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг тус тус дүүргэсэн. 2010 онд АНУ-ын Үндэсний их сургуульд Санхүүгээр мэргэшсэн Бизнесийн удирдлагын мастерийн зэрэг хамгаалсан. Г.Цогбадрах нь Голомт Банкинд гадаад төлбөртооцооны нягтлан бодогч, Дунай ХХК-д менежер, Хөгжлийн Алтан Сан ББСБ-ын салбарын бүсийн захирлаар тус тус ажиллаж байсан. Хас Банк байгуулагдсан цагаас 2008 он хүртэл Дотоод аудит, Салбарын удирдлага,

Санхүү бүртгэл, Хөрөнгө зохицуулалтын газрын захирлаар, 2010-2011 онд Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн Хөрөнгө оруулалт эрхэлсэн захирлаар, 2011-2014 онд Тэнгэр Даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар тус тус ажиллажээ. Г.Цогбадрах 2005 оноос Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Секюритиз ҮЦК ХХК, Ард Менежмент ХХК-иудын ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр өдгөө Ард Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирлаар болон ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна.



Чулуун Ганзориг

ТУЗ-ийн ердийн гишүүн

Ч. Ганзориг нь 2004 онд Нийслэлийн 10 жилийн 23-р дунд сургуулийг, 2007 онд Шанхайн их сургууль, 2010 онд Унгар улсын Будапешт хотын Корвинусын их сургуулийг тус тус төгссөн. Ч.Ганзориг нь ХасБанкны тооцооны төвийн харилцагчийн үйлчилгээний ажилтан, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл, Тэнгэр Даатгал, Унгар улсын Wallis Asset Management зэрэг байгууллагуудад сайн дурын дадлагын ажилтан, Ард Санхүүгийн Нэгдэл ХК, Ард Секюритиз ҮЦК ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээч, мэргэжилтнээр тус тус ажиллаж байсан туршлагатай. Ард Кредит ББСБ-ын үүсгэн байгуулагч,

Гүйцэтгэх захирал Ч.Ганзориг нь 2013 оноос 2019 оныг хүртэл Ард Кредит ББСБ ХК-д Гүйцэтгэх захирлаар ажиллаж байв. Энэ хугацаанд Ард Дижитал Банкны төслийг амжилттай хэрэгжүүлсэн ба Ард Кредит ББСБ-ын IPO-г хийж 5.5 тэрбум төгрөгийг босгож чаджээ. Тэрээр Ард Кредит компанийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд хөрөнгө оруулагчдын нэг юм. Ч.Ганзориг нь Номадик Офф-Ред компанийн үүсгэн байгуулагч бөгөөд өдгөө Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2018 оны 4 сарын 19-ний өдрөөс Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Батбилэг Золбоо

ТУЗ-ийн ердийн гишүүн

Б.Золбоо нь 2012 онд ОХУ-ын Элчин сайдын яамны 14-р сургууль, 2013 онд Санхүү эдийн засгийн их сургууль, 2016 онд АНУ-ын Нью Йорк муж дахь Plattsburgh College-ийг тус тус дүүргэсэн. Тэрээр J.P. Morgan-ий харъяа компани болох Primary Insight, FINRA итгэмжлэгдсэн брокерын Darwood Associates зэрэг компаниудад дадлагажигч, Ард Секюритиз

ҮЦК ХХК, Ард Менежмент ХХК-д хөрөнгө оруулалтын шинжээчээр тус тус ажиллаж байв. 2019 онд Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү эрхэлсэн захирлаар томилогдон өнөөг хүртэл ажиллаж байна. Тэрээр мөн 2018 оноос одоог хүртэл Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр ажиллаж байна.



Сүхдорж Оргил

ТУЗ-ийн ердийн гишүүн

С.Оргил нь 1998 онд Нийслэлийн 10 жилийн 23-р дунд сургууль, 2002 онд Австралийн Улсын "AlphaBeta" коллеж, 2006 онд Сиднейн технологийн их сургуулийг тус тус төгссөн байна.

С.Оргил нь Гаалийн Ерөнхий Газарт МХТ/Худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, МОСТ ПСП ХХК-д

Ерөнхий захирал, мөн тус компанийн Үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байгаад 2019 оноос одоог хүртэл Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. 2018 оны 12 сарын 13-нд Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр түр томилогдсон бөгөөд 2019 оны 4 сарын 27-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдсон.



Зоригт Ариун

ТУЗ-ийн хараат бус гишүүн

2005 онд ОХУ-ын ЭСЯ-ны дэргэдэх 14-р дунд сургуулийг төгссөн. 2006-2010 оны хооронд АНУ-ын Индиана муж дахь Валпарайсогийн Их сургуулийг Бизнесийн менежмент, банк санхүүгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн. 2014 онд БНФранц Улсын INSEAD сургуульд Бизнесийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалсан.

Улаанбаатар дахь Америк сургуульд Сурагчдын үйлчилгээний менежерээр, 2012- 2013 оны хооронд тус сургуульдаа бизнес хариуцсан менежерийн албан

тушаалд томилогдон ажиллажээ. 2016 оноос 2019 он хүртэл Улаанбаатар дахь Америк сургуульд зөвлөх багшаар үргэлжлүүлэн ажилласан туршлагатай. Тэрээр 2011 оноос хойш үл хөдлөх хөрөнгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Инсигниа ХХК, 2018 оноос хойш хүлэмжийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Арвин Баялаг Хүнс ХХК- зэрэг компаниудыг амжилттай удирдан ажиллаж байна. Түүнчлэн 2018 оноос Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Баатарзориг Болорчимэг

ТУЗ-ийн хараат бус гишүүн

Б.Болорчимэг нь 2012 онд Монгол Улсын Боловсролын Их Сургуулийг Монгол-Англи хэлний багш мэргэжлээр, Хэвлэлийн хүрээлэнд сэтгүүлч мэргэжлээр суралцан төгссөн. 2016 онд Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Бизнесийн удирдлагаар магистрын зэрэг хамгаалжээ.

Б.Болорчимэг нь “Шинэ дэлхий”, MNC, NTV телевизүүдэд сэтгүүлч, хөтлөгч, редактороор ажиллаж байсан туршлагатай нэгэн. 2019 оноос Өрөг.мн контент сайтаа ажиллуулж байгаа. 2018 оноос эхлэн Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн Хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна.



Ичинхорлоо Сэр-Од

ТУЗ-ийн хараат бус гишүүн

И.Сэр-Од нь 1998 онд МУИС-ийг захиргааны эрхзүйч мэргэжлээр, 2006 онд АНУ-ын Далласхотноо “Америк болон олон улсын хуулийн академи”-д суралцан төгссөн. И.Сэр Од нь Монголын Бизнес Мэдээллийн сангийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч Захирал бөгөөд тэрээр Монголын бизнесийн гол төлөөлөх байгууллагууд болох Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимд Газрын Дарга, Монголын Бизнесийн Зөвлөлийн Дэд Захирал зэрэг

албан үүргийг тасралтгүй 20 жил гүйцэтгэсэн. Тэрээр УИХ-ын Тамгын Газрын Парламент хоорондын харилцааны хэлтэст Зохион байгуулагч, MCS компанид Экспортын Менежерын ажил үүрэг гүйцэтгэж байсан. И. Сэр-Од мөн Монноос компанийн Удирдах Зөвлөлийн гишүүн бөгөөд АНУ-ын Олон Улсын Хуулийн Академийн Монгол Улс дахь Зохицуулагчийн сонгуульт ажилтай.

ТУЗ-ийн хурал

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 онд нийт 5 удаа ээлжит хурал, нэг удаа ээлжит бус хурал

зохион байгуулсан бөгөөд цаг үеийн тулгамдсан чухал асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэж ажиллалаа.

Огноо	Ирц	Шийдвэрлэсэн асуудлууд
2019.2.18 /ээлжит/	89%	1. Ард Даатгал ХК-ийн 2018 оны цэвэр ашгаас 50%-иар тооцож ногдол ашиг хуваарилах 2. Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4 сарын 27-ны өдөр зохион байгуулах 3. ТУЗ-ийн гишүүн Б.Гантулгыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх 4. Компанийн дотоод заавар, журам, бодлогын баримт бичиг батлах 5. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар Ж.Дамбаасүрэнг томилох
2019.4.23 /ээлжит/	89%	1. Гүйцэтгэх захирлын 2018 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийг батлах 2. Гүйцэтгэх захирлын 2019 оны төлөвлөгөөг батлах
2019.7.16 /ээлжит/	77.78%	1. ТУЗ-ийн дэд хороодыг шинэчлэн томилох 2. ТУЗ-ийн даргыг томилох
2019.10.16 /ээлжит/	77.78%	1. 2019 оны 3-р улирлын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, Эрсдэлийн тайлан зэрэг асуудлаар хэлэлцэв.
2019.12.6 /ээлжит бус/	100%	1. Эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах 2. Өөрийн эрсдэл болон төлбөрийн чадвараа үнэлэх бодлогыг батлах
2019.12.16 /ээлжит/	89%	1. 2020 оны төсөв, төлөвлөгөө батлах 2. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар Э.Гэрэлчимэгийг томилохыг зөвшөөрч, зохих зөвшөөрлийг СЗХ-ноос авах 3. ТУЗ-ийн гишүүдийн цалинг батлах

ТУЗ-ийн гишүүдийн Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшсэн байдал, цалин

Д/д	Албан тушаал	Цалингийн хэмжээ	
		ТУЗ-ийн ээлжит хуралд оролцоход	ТУЗ-ийн дэргэдэх хорооны хуралд оролцоход
2	ТУЗ-ийн гишүүд	600,000 төгрөг	300,000 төгрөг

/ТУЗ-ийн гишүүдийн цалинг хурлын ирц дээр үндэслэн олгоно/

ТУЗ-ийн гишүүдийн хувьцааны талаарх мэдээлэл 2019 оны 12 сарын 31-ний байдлаар

Д/д	ТУЗ-ийн гишүүн	Ард Даатгал ХК-ийн хувьцаа	Эзлэх хувь	Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн хувьцаа	Эзлэх хувь
1	Ч.Ганхуяг	-	-	1,224,374	4.27%
2	Г.Цогбадрах	71,772	0.28%	159,747	0.55%
3	О.Одбаяр	-	-	-	-
4	Б.Золбоо	47,739	0.19%	12,401	0.04%
5	Ч.Ганзориг	12,044	0.04%	46,297	0.16%
6	С.Оргил	-	-	-	-
7	Б.Болорчимэг	9,086	0.03%	-	-
8	З.Ариун	11,404	0.04%	156	-
9	И.Сэр-Од	-	-	-	-

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Ард Даатгал ХК-ийн ТУЗ нь компанийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар явуулах зорилгоор Аудитын хороо, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо, Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороотой байна.

Аудитын хороо

Аудитын хороо нь компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, аудитын байгууллагыг сонгох зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга З.Ариун

Хорооны гишүүд: О.Одбаяр, И.Сэр-Од

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны зорилго нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийг ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнуудыг сонгон шалгаруулах, тэдгээрийн ажил үүргийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, тэдгээрийн цалин, урамшууллыг томьёолох, тогтоох, компанийн хэмжээнд цалин урамшууллын бодлогыг тодорхойлох, эдгээрийн талаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал, дүгнэлт гаргах чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршино.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Ч.Ганзориг

Хорооны гишүүд: Б.Болорчимэг, З.Ариун

Санхүү, эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо

Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо нь компанийн стратеги төлөвлөгөөг боловсруулж ТУЗ-д танилцуулан батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн тайлан, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн стратеги төлөвлөлтөд нийцсэн эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах, компанийн хувьцааны үнэ цэнийг дээшлүүлэх, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Бүрэлдэхүүн: Хорооны дарга Б.Золбоо

Хорооны гишүүд: Г.Цогбадрах, И.Сэр-Од, С.Оргил, Б.Болорчимэг

ТУЗ-ийн Хороодын хуралдсан байдал

Хороо	Хэлэлцсэн асуудлууд
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2019.2.18	1. Гүйцэтгэх захирлын 2018 оны KPI гүйцэтгэл 2. 2019 оны KPI 3. ТУЗ-ийн гишүүдэд нэр дэвшигчдийн асуудал
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2019.4.23	1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлын явц, ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулга 2. Гүйцэтгэх захирлын KPI
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2019.10.16	1. Хорооны дарга сонгох 2. Хувьцаа хуваарилалтын тайлан
Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо 2019.12.16	1. ТУЗ-ийн төсөв 2. ТУЗ-ийн Нарийн бичгийн даргыг сонгох тухай;
Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо 2019.2.18	1. 2018 оны 4-р улирлын тайлан 2. Ногдол ашиг хуваарилах тухай 3. Мөнгө угаах терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн тухай
Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо 2019.4.23	1. 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлан 2. 2018 оны дүгнэлт
Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо 2019.10.15	1. Дарга сонгох 2. 3-р улирлын санхүүгийн тайлан 3. Эрсдэлийн тайлан (ORSA) 4. Авлагын тухай
Эрсдэл, хөрөнгө оруулалтын хороо 2019.12.12	1. 2020 оны төлөвлөгөө, төсөв 2. 2020 оны ТУЗ-ийн төсөв 3. МУТСТ тухай хуулийн хэрэгжилт;
Аудитын хороо 2019.2.18	1. Ховд аймаг дах салбарт хийсэн шалгалтын тайлан 2. Борлуулалтын албаны менежерүүдийн ажилд хийсэн шалгалтын тайлан
Аудитын хороо 2019.10.16	1. Дарга сонгох 2. Орон нутгийн салбаруудад хийсэн шалгалтын ажлын тайлан 3. Аудитын албаны 2020 онд хийх ажлын төлөвлөгөө

Удирдлагын баг

Ард Даатгал ХК нь 2017 оноос хойш Гүйцэтгэх захирал, Даатгалын газрын захирал, Эрсдэлийн удирдлагын газрын захирал, Санхүү удирдлагын газрын захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал гэсэн удирдлагын багтайгаар ажиллаж байна. Тайлант хугацаанд удирдлагын багт ямар нэгэн өөрчлөлт гараагүй байна.

Ногдол ашгийн тайлан

Ард Даатгал ХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 2 сарын 18-ны өдрийн №2/19 тоот тогтоолын дагуу компанийн 2018 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчиддээ нэгж хувьцаанд 25.27 төгрөг буюу цэвэр ашгийн 50 хувь болох нийт 632 сая төгрөгийн ногдол ашгийг хуваарилахаар шийдвэрлэсэн.

Ногдол ашгийг 2019 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр буюу 2019 оны 3 сарын 15-ны байдлаар Ард Даатгал ХК-ийн хувьцааг эзэмшиж байгаа нийт хувьцаа эзэмшигчдэд олголоо.

Компанийн зарласан ногдол ашгийг 2019 оны 6 сарын 17-ны өдрөөс 6 сарын 26-ны өдрийг хүртэл анх удаа компанийн байранд тараасан. Тухай үед компани дээр биеэр хүрэлцэн ирж амжаагүй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр зуучлуулан хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасны хадгаламжийн дансанд шилжүүлээ.

НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бид компанийн нийгмийн хариуцлагыг байнга ухамсарлаж, 2019 онд тус зорилгынхоо хүрээнд дараах ажлуудыг хамт олноороо хийж гүйцэтгэлээ.

Эрүүл мэндийн даатгалын ач холбогдлыг иргэдэд таниулах, даатгуулагчдад ойлголт өгөх зорилгоор Эмнэлгийн менежментийн хурал анхдугаар чуулганыг Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэгтэй хамтран амжилттай зохион байгуулж Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа улсын болон хувийн бүхий л эмнэлгийн байгууллага, тэдгээрийн эмч эмнэлгийн ажиллагсдыг хамрууллаа.



Монголын даамын холбоотой хамтран 100 буудалт даамын залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан.

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам, Монголын Хөлбөмбөгийн Холбоо хамтран зохион байгуулдаг “Дуулиан-2020” тэмцээнд Нийслэлийн 106, 107 дугаар сургуулийн өсвөр үеийн тамирчдыг уламжлал ёсоор ивээн тэтгэж дэмжин ажиллалаа.



“ABU РОБОКОН-2019” тэмцээнд Монгол Коосэн технологийн коллежийн МОКО багийг дэмжин хамтран ажилласан.



Цус сэлбэлт судлалын үндэсний төвд ажилчид цусаа хандивлалаа.

БСШУСЯам Боловсрол суваг телевизийн хамтран хэрэгжүүлсэн “Би багш” төсөл нэвтрүүлгийн ерөхний ивээн тэтгэгчээр ажиллаж, Монголын боловсролын салбарыг хөгжүүлэхэд үйлсэд зохих хувь нэмрээ орууллаа.



Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилтот контеь болох “Эмчийн эсрэг интернет” нэвтрүүлгийг ивээн тэтгэв.







ХҮНИЙ НӨӨЦ

Ард Даатгал ХК нь 2019 оны жилийн эцсийн байдлаар даатгалын салбарт мэргэшсэн туршлагатай 99 ажиллагсадтай үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 45 хувь нь орон нутгийн салбарт ажиллаж байна.

Компанийн хүний нөөцийн бодлогын хүрээнд нийт ажиллагсдыг эрүүл мэндийн асуудалд анхаарах үүднээс эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалд хамруулан, спорт заалуудтай гэрээ хийж ажиллагсдын эрүүл амьдралын хэв маягийг бүрдүүлэн ажилладаг. Ажиллагсдын гэнэтийн осол, эрүүл мэндийн даатгалд компани 2019 онд нийт 22,876,712 төгрөгийг зарцуулж, нийт 75 ажиллагсад болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг хамрууллаа. Мөн ирээдүйн хуримтлалыг бий болгох үүднээс тэтгэврийн хуримтлалын санд хамруулж, ажил олгогчийн зүгээс 2019 оны турш 18,017,729.99 төгрөгийг зарцуулсан ба нийгмийн даатгалын шимтгэлд байгууллагаас 222,510,151.50 төгрөг, ажиллагсдаас 164,518,860.68 төгрөгийг төлжээ. Мөн ажиллагсдад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор ажиллагсдын санаачилгаар үүсгэн байгуулсан "ИАЙТи" ХХК-ийн хувьцаанаас хөнгөлөлттэй үнээр худалдаж авах боломж олголоо. Манай компани сул ажлын байрыг нээлттэй бодлогын хүрээнд зарлаж, өөрийн ажиллагсдаас гадна дотоод болон гадаадын их сургуулийн төгсөгчид, мөн туршлагатай ажил горилогчдоос хүний нөөцийн бүрдүүлэлтээ хийн ажиллалаа. 2019 оны турш компанид шинээр 14 хүн ажилд орж, 13 хүн өөрийн болон ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдсөн байна.


Бид зөвхөн мэргэжлийн боловсон хүчин цуглуулах биш, ажиллагсдаа давтан сургах, багаар ажиллах чадварыг хөгжүүлэхэд голчлон анхаардаг бөгөөд Япон, Сингапур зэрэг улсуудад даатгалын мэргэшлийн сургалтад хамруулсан. Мөн дотоодын

10 гаруй сургалтыг зохион байгуулж, МДХ, СЗХ болон бусад байгууллагуудаас зохион байгуулдаг 20 гаруй сургалтад ажиллагсдаа хамрууллаа.


Мөн хамт олны дундаас ажил хөдөлмөрөөр тэргүүлсэн Ард Даатгал ХК-ийн үүсгэн байгуулагч Ч.Тогтохбаяр "Гавъяат эдийн засагч" цолоор, Даатгалын ерөнхий менежер Б.Янжмаа, Орхон салбарын захирал Ю.Дуламсүрэн нар "Алтан гадас" одон, Багануур салбарын захирал Т.Баярхүү Санхүүгийн Зохицуулах Хорооны "Санхүү банкны тэргүүний ажилтан" цол тэмдэг, Нягтлан бодогч О.Шинэцэцэг Сангийн яамны "Хүндэт жуух бичиг"-ээр, Даатгалын менежер Ч.Нарангэрэл, Эрсдэлийн шинжээч Б.Нямдэлгэр, Нягтлан бодогч Д.Буянхишиг нар Санхүүгийн Зохицуулах Хорооны "Хүндэт жуух бичиг"-ээр, Монголын даатгалын холбооноос "Оны шилдэг даатгалын менежер"-ээр Даатгалын менежер Ү.Мөнхсарнай, "Оны шилдэг санхүүч"-ээр Ц.Ариунцэцэг, "Оны шилдэг нөхөн төлбөрийн менежер"-ээр Б.Наран-Эрдэнэ нар, Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу алтан медаль"-иар Нөхөн төлбөрийн ажилтан А.Энхбаяр, Шуурхай дуудлагын ажилтан Г.Батсүрэн нар, "Хөдөлмөрийн алдар" алтан медалиар Архангай аймаг дахь салбарын даатгалын менежер Д.Гончиг, Хуульч Ж.Дамбаасүрэн, Маркетингийн менежер Н.Хандмаа, Эрсдэлийн шинжээч Г.Гантигмаа, Шуурхай дуудлагын ажилтан П.Одсүрэн, Даатгалын менежер Ц.Билгүүн нар тус тус шагнагдлаа. Эрсдэлийн шинжээч Г.Гантигмаа, Шуурхай дуудлагын ажилтан П.Одсүрэн, Даатгалын менежер Ц.Билгүүн нар тус тус шагнагдлаа.

Хүний нөөцийн тоо баримтууд


Ажиллагсдын хүйсийн харьцаа:



Компанид ажилласан жил:



Ажиллагсдын насны бүтэц:



/2019 оны байдлаар/







ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, бичлэгжуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“АРД ДААТГАЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Ард Даатгал ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого үр дүн, бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь “Ард Даатгал” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Аудитлагдсан Санхүүгийн Тайлан, түүний нэмэлт тодруулгатай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС-ын) шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн

Зохицуулах Хорооноос баталсан даатгалын компанийн нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу илэрхийлэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайланг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба бидний дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон банкны санхүүгийн тайланд хязгаарлалтгүй санал дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол асуудал

асуудлын талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн чухал асуудал байдаг.

Хураангуй тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх,

түүндээ үндэслэн хураангуй санхүүгийн тайлангаа үнэн зөв бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Компаниа бэлтгэсэн хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэхийг шалгах,

АОУС 810 буюу “Хураангуй санхүүгийн тайлангийн талаар тайлагнах гэрээт ажлууд”-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж дүгнэлт өгөх явдал юм.



2020 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 18-НЫ ӨДӨР

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

	2019.12.31 мянган төгрөг	2018.12.31 мянган төгрөг
ХӨРӨНГӨ		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	422,095.4	315,828.3
Хөрөнгө оруулалт	15,179,496.5	14,371,951.3
Даатгалын авлага	755,867.9	1,177,362.8
Бусад санхүүгийн хөрөнгө	1,129,819.0	1,388,860.6
Бусад санхүүгийн бус хөрөнгө	611,568.4	502,072.0
Даатгалын хөрөнгө	1,514,608.1	2,117,279.1
Өмч, барилга, тоног төхөөрөмж -цэвэр	1,036,617.2	1,129,789.2
Биет бус хөрөнгө	173,590.1	
НИЙТ ХӨРӨНГӨ	20,823,662.6	21,003,143.3
ӨР ТӨЛБӨР		
Даатгалын өр төлбөр	699,938.1	1,315,097.4
Бусад санхүүгийн өр төлбөр	109,277.6	350,174.0
Бусад санхүүгийн бус өр төлбөр	329,298.8	148,682.8
Нөхөн төлбөрийн нөөц сан:		
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	4,875,238.2	6,178,177.5
Учирсан боловч мэдэгдээгүй ХНС	1,082,321.6	931,487.4
Мэдсэн боловч төлөөгүй ХНС	335,203.1	103,592.5
Учирч болзошгүй ХНС	946,122.9	615,268.5
Тусгай нөөц сан	641,252.8	641,252.8
Нийт нөөц сан	7,880,138.6	8,469,778.6
Нийт өр төлбөр	9,018,653.1	10,283,732.9
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		
Энгийн хувьцаа	5,000,000.0	5,000,000.0
Нэмж төлөгдсөн капитал	3,280,854.5	3,280,854.5
Хуримтлагдсан ашиг	3,524,155.0	2,438,556.0
Нийт өөрийн хөрөнгө	11,805,009.5	10,719,410.5
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	20,823,662.6	21,003,143.3

ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

	2019.12.31 мянган төгрөг	2018.12.31 мянган төгрөг
Даатгалын үйл ажиллагаа		
Даатгалын хураамжийн орлого	11,409,424.5	13,001,384.8
Даатгалын хураамжийн буцаалт	(431,197.5)	(228,468.2)
Давхар даатгалын хураамжийн зардал	(2,082,096.6)	(3,163,478.5)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	8,896,130.4	9,609,438.2
Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	1,302,939.2	(2,283,234.0)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(575,265.1)	749,049.4
Орлогод тооцсон хураамж	9,623,804.5	8,075,253.6
Нөхөн төлбөрийн зардал	(4,423,370.6)	(6,012,374.1)
Давхар даатгагчийн төлсөн нөхөн төлбөр	450,786.7	2,395,056.6
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	123,843.2	129,451.4
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	(3,848,740.7)	(3,487,866.1)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	(382,444.8)	(473,757.2)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	125,658.5	(16,645.1)
Учирч болзошгүй хохирлын нөөцийн сангийн өөрчлөлт	(330,854.4)	(153,195.5)
Зардалд тооцсон нөхөн төлбөр	(4,436,381.4)	(4,131,464.0)
Даатгалын гэрээний зардал	(1,953,933.1)	(1,441,187.6)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	180,383.2	116,864.3
Хөрөнгө оруулалтын олз, гарз	2,410,782.4	1,756,925.5
Даатгалын үйл ажиллагааны ашиг/ (алдагдал)	5,824,655.6	4,376,391.8
Ажиллагсадтай холбоотой зардал	(2,174,924.0)	(1,811,035.8)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ЗАРДАЛ	(1,662,002.1)	(1,517,643.7)
Үйл ажиллагааны бусад орлого	208,029.8	133,723.4
Хөрөнгө данснаас хассаны олз/(гарз)	(3,065.6)	417,421.7
Үйл ажиллагааны бус зардал	(231,201.4)	(206,303.6)
Санхүүгийн орлого/(зардал)	39,197.0	(5,747.1)
Бусад ашиг/(алдагдал)	(3,823,966.3)	(2,989,585.2)
Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)	2,000,689.3	1,386,806.7
Орлогын албан татварын зардал	(281,940.2)	(123,403.2)
Татварын дараах ашиг/(алдагдал)	1,718,749.0	1,263,403.5
Нэгж хувьцаанд ногдох ашиг-төгрөгөөр	68.75	65.16

Хүчтэй. Хамтдаа.

 www.arddaatgal.mn  info@arddaatgal.mn  [arddaatgal](https://www.facebook.com/arddaatgal)  [arddaatgalmn](https://twitter.com/arddaatgalmn)  [цэнэг.эрдэмтэй.өнгөлөх](https://www.telegram.me/cenag.arddamtai.ongoloh)  7720 0089

Хаяг: Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар, Ерөнхий Сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот 14200, Монгол улс